

Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



Зүрхнээс зүрхэнд сайн мэдээг хуваалцах нь

Бурхан сайн мэдээг хуваалцах хүсэлтэй, бэлтгэгдсэн үйлчлэгч нартаа сайн мэдээг хүлээн авахад бэлэн хүмүүстэй уулзахад тусалдаг. Та нарын амьдралд ч гэсэн тийм зүйл тохиолдсон байгаа. Иймэрхүү зүйл хэр ойрхон тохиолдох нь та нарын зүрх сэтгэл, бодол санаатай шууд холбоотой.

Миний нэг найз сайн мэдээг хүлээн авахад бэлэн хүмүүстэй уулзуулж өгөөч гэж өдөр бүр залбирдаг. Тэрээр үргэлж Мормоны Номыг өөртөө авч явдаг. Нэгэн удаа аялалд явахынхаа өмнөх орой тэрээр Мормоны Номын оронд Сүмийн танилцуулгатай карт авч явахаар шийджээ. Гэвч яг явахынх нь өмнө “Мормоны Ном авч явах хэрэгтэй” гэсэн сүнслэг мэдрэмж түүнд төрсөн бөгөөд тэр нэг Мормоны Номыг авч цүнхэндээ хийсэн юм.

Онгоцонд түүний хажууд таньдаг эмэгтэй нь сууж байлаа. Буцахдаа ч нөгөө эмэгтэйтэй хамт суулаа. “Сайн мэдээний тухай хэрхэн ярих билээ?” хэмээн тэрээр боджээ.

Тэгтэл харин өнөөх эмэгтэй “Та нар сүмдээ аравны нэг төлдөг тийм үү?” хэмээн түүнээс асуулаа. Тэр тийм хэмээн хариулав. Өнөөх эмэгтэй би ч гэсэн сүмдээ аравны нэгээ төлөх ёстой гэхдээ би төлдөггүй юм гээд түүнээс “Мормоны Номын талаар та надад юу хэлж чадах вэ?” гэж асуув.

Мормоны Ном нь Бошиглогч Иосеф Смитээр орчуулагдсан судар бөгөөд Есүс Христийн бас нэгэн гэрээ юм гэж тэр тайлбарлав. Түүнийг ийн хэлэхэд эмэгтэй сонирхож байх шиг түүнд санагдав. “Энэ номыг авч явах хэрэгтэй гэсэн мэдрэмж надад төрсөн юм. Танд өгөх хэрэгтэй байхаа” гэж тэр хэлжээ.

Эмэгтэй номыг уншиж эхэллээ. Биднийг салах мөчид тэрээр “Хоёулаа энэ тухай дахиад ярилцана аа” гэж тэр хэлэв.

Энэ эмэгтэй сүм хайж байсныг найз маань мэдээгүй байсан ч Бурхан *мэдэж байсан юм*. Тэр эмэгтэй найзыг маань хараад сүм яагаад түүнийг ийм аз жаргалтай болгосон юм бол хэмээн гайхширч байсныг Бурхан мэдэж байсан юм. Тэр эмэгтэй Мормоны Номын тухай асууж мөн номлогч нараар заалгах хүсэлтэй байх болно гэдгийг Бурхан мэдэж байлаа. Тэр бэлтгэгдсэн байсан. Миний найз ч мөн адил бэлтгэгдсэн байсан. Та бид ч мөн бэлтгэгдэж чадна.

Бид бодол санаа, зүрх сэтгэлээ бэлтгэх хэрэгтэй. Тэр эмэгтэй Мормоны Номын тухай, Их Эзний сэргээгдсэн Сүмийн тухай мөн аравны нэгээ төлөх Бурханы тушаалын тухай сонсож, санасан ажээ. Тэр бас үнэний тухай гэрчийг зүрх сэтгэлдээ мэдэрч эхэлсэн байв.

Их Эзэн бидний оюунд болоод зүрх сэтгэлд

үнэнийг ярих болно хэмээн хэлсэн билээ. (С ба Г 8:2-г үзнэ үү). Та нарын уулзах ихэнх хүнд тэрхүү бэлтгэл эхэлсэн байдаг. Тэд Бурханы тухай мөн Түүний үгсийг сонсож, уншсан байдаг. Хэрэв тэдний зүрх сэтгэл зөөлөн аваас үнэний баталгааг бага ч гэсэн мэдэрсэн байдаг.

Тэр эмэгтэй бэлтгэгдсэн байсан юм. Мормоны Номыг судалсан Хожмын Үеийн Гэгээнтэн найз маань ч мөн бэлтгэгдсэн байсан. Энэ бол үнэн гэдэг гэрчлэлтэй бөгөөд Мормоны Ном ав хэмээсэн Сүнсний удирдамжийг таньж мэдэрсэн. Тэр оюун болоод зүрх сэтгэлдээ бэлтгэгдсэн байлаа.

Бурхан сэргээгдсэн үнэний тухай таны гэрчлэлийг хүлээн авах хүмүүсийг бэлтгэж байгаа. Бурхан таны итгэлийг мөн танд болон таны хайртай хүмүүсийн хувьд үнэтэй болсон тэрхүү зүйлийг айхгүйгээр хуваалцах үйлдлийг шаарддаг.

Өдөр бүр сайн мэдээний үнэнээр оюун бодлоо цэнэглэж, бусадтай хуваалцахад бэлтгэ. Та тушаалуудыг дагаж, гэрээнүүдээ хүндэтгэснээр Сүнсний гэрчлэлийг болон таныг, таны уулзах хүмүүсийг хайрлах Аврагчийн хайрыг мэдрэх болно.

Та өөрийн хийх ёстой зүйлээ хийх аваас үнэний тухай гэрчлэлийг тань сонсохоор бэлтгэгдсэн илүү олон хүмүүстэй уулзаж, таны зүрх сэтгэлээс тэдний зүрх сэтгэлд хүрэх сайхан боломжийг та олох болно.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Захиасыг гэр бүлийнхэнтэйгээ уншиж, гэрчлэлээ хүчирхэгжүүлэх арга замын талаар Ерөнхийлөгч Айрингийн хэлсэн дараах үгсийг харилцан ярилц. Сайн мэдээг хуваалцаж байхдаа гэрчлэлээ

хуваалцахын чухлыг гэр бүлийнхэнтэйгээ ярилц. Танай гэр бүлд хүүхдүүд байдаг бол найзтайгаа гэрчлэлээ хэрхэн хуваалцаж болох тухай жүжигчлэн үзүүлбэл тустай байж болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Юу хэлэхээ мэдэх нь

Сайн мэдээг бусадтай хуваалцах хангалттай мэдлэггүй гэж өөрийгөө боддог бол сударт бичсэн дараах тайвшруулах амлалтуудыг сана:

“Энэ хүмүүст дуу хоолойгоо өргөгтүн; зүрх сэтгэлд тань миний тавих бодлуудыг яригтун, мөн та нар хүмүүсийн өмнө мэдлэгдэх нь үгүй;

Учир нь тийм ээ, та нар юу хэлэх ёстой нь яг тухайн цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 100:5–6).

“Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно” (Иохан 14:26).

Эдгээр нь үнэхээр агуу амлалтууд боловч эдгээрийг хүлээн авахын тулд бид хийх ёстой зүйлээ хийх ёстой. Энэ захиаст Ерөнхийлөгч Айринг бидэнд “Өдөр бүр сайн мэдээний үнэнээр оюун бодлоо цэнэглэж, бусадтай [сайн мэдээг] хуваалцахад бэлтгэ” хэмээн заасан. Сайн мэдээний үнэнээр оюун бодлоо цэнэглэхийн тулд бид юу хийж чадах вэ?

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Хуваалцахад бэлтгэ

Оюун бодлоо сайн мэдээний үнэнээр цэнэглэх нь сайн мэдээг хуваалцахад бэлтгэх чухал арга гэж Ерөнхийлөгч Айринг хэлсэн байдаг. Сайн мэдээг хуваалцахад бэлтгэхийн тулд та юу хийж чадах вэ?



Итгэл, Гэр бүл, Халамж

Тусгай хэрэгцээ ба үйлчлэл үзүүлсэн нь

Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

“Хүмүүст тусламж үргэлж хэрэгтэй байдаг бөгөөд бид тэдний төлөө ямар нэг зүйл хийж чадна.” . . . Бид бусдад чин сэтгэлээсээ үйлчилж, өөрсдийн асуудлаа мартажгүй аваас бидний амьдрал маш өчүүхэн зорилготой байх болно” гэж Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлсэн юм.¹

Айлчлагч багш нарын хувьд бид айлчилж очдог эгч нараа чин сэтгэлээсээ таньж мэдэж чадна. Айлчлан очдог эгч нараа хайрлах хайраас маань бидний үйлчлэл ундрэн гарах болно (Иохан 13:34–35-г үзнэ үү).

Хэрэгтэй үед нь эгч нартаа үйлчлэхийн тулд бид тэдний сүнслэг болон материаллаг хэрэгцээг нь хэрхэн мэдэж чадах вэ? Бид айлчлан очдог эгч нарынхаа төлөө залбирахдаа тэрхүү удирдамжийг хүлээн авч чадна.

Эгч нартайгаа үргэлж холбоотой байх нь бас чухал юм. Айлчлан очих, утсаар ярих, урамшуулан дэмжих зурвас болон э-мэйл бичих, түүнтэй сууж ярилцах, чин сэтгэлээсээ магтан сайшаах, сүм дээр ярилцах, өвчтэй юм уу тусламж хэрэгтэй үед нь туслах зэрэг үйлчлэлийн бусад олон үйлдэл нь биднийг нэг нэгнээ харж халамжлан, хүчирхэгжүүлэхэд тусалдаг билээ.²

Айлчлагч багш нар эгч нарын амьдрал ямархуу байгааг болон

ямар нэгэн онцгой тусламж хэрэгцээ байгаа эсэхийг мөн тэдэнд хэрхэн үйлчилсэн талаар тайлагнах ёстой. Энэ төрлийн тайлан болон эгч нартаа үзүүлэх үйлчлэл нь бидний дуулгавартай байдлыг харуулдаг.³

Судруудаас

Иохан 10:14–16; 3 Нифай 17:7, 9; Моронай 6:3–4

Бидний түүхээс

Айлчлагч багшийн хамгийн гол зорилго нь нэг нэгэндээ үйлчлэх явдал билээ. Ийм үйлчлэл нь зүгээр нэг сар бүрийн айлчлал биш харин сайн үйлс болон нөхөрлөлийг бидэнд авчирдаг. Хамгийн чухал нь тэднийг гэх бидний сэтгэл зүтгэл чухал юм.

Нийгмийн Халамжийн Бүлгийн 13 дахь Ерөнхий ерөнхийлөгч Мэри Эллин Смүүт эгч “эгч нар маань утсаар ярих мөн сар бүр эсвэл улиралд нэг удаа айлчлан очих гэж санаа зовдог явдлаа зогсоохыг би хүсч байна. Харин үүний оронд уян зөөлөн бодгалиудыг тэжээн тэтгэх тал дээр анхаарна уу” хэмээн биднээс хүссэн.⁴

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985) “Хаант улсад бид нэг нэгэндээ үйлчлэх нь амин чухал юм” хэмээн заасан билээ. Гэвч бүх үйлчлэл нь том

баатарлаг үйлчлэл байх шаардлагагүй гэдгийг тэр мэддэг байсан.

“Бидний үйлчлэл нь зүгээр л урам дэм өгөх эсвэл жижиг зүйл дээр туслах зэрэг энгийн үйлдлүүдийг шаардах нь олонтоо байдаг.

Гэхдээ ийм жижигхэн боловч үр ашигтай үйлдлүүд нь ямар гайхалтай агуу үр дүн авчирдаг билээ” гэж тэр хэлсэн юм.⁵

Эшлэл

1. Томас С.Монсон, “What Have I Done for Someone Today?” *Лианахона*, 2009 оны 11-р сар, 85.
2. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 9.5.1-ийг үзнэ үү.
3. *Гарын авлага 2*, 9.5.4-ийг үзнэ үү.
4. Мэри Эллин Смүүт, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 117.
5. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Спенсер В.Кимбалл* (2006), 82.

Би юу хийж чадах вэ?

1. Харж хандан туслахаар томилогдсон эгч нарынхаа сүнслэг болон материаллаг хэрэгцээг мэдэхийн тулд би хувийн илчлэлт хүлээн авахаар эрэлхийлж байгаа юу?
2. Миний харж хандан туслах эгч нар маань тэднийг болон тэдний гэр бүлийнхнийг хайрладагийг минь хэрхэн мэдэж болох вэ?

Нэмэлт мэдээллийг www.reliefsociety.lds.org-аас үзнэ үү.